



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/149/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegnaab@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2025/149/НА-СТА-ТШЗ



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.02.21

№

39

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын онцолсон хэсэг

Тайлант онд Боловсролын яам, Боловсролын ерөнхий газраас 18 сургууль, цэцэрлэгт шаардлагатай 728 төрлийн 343,900.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн байна. Аймгийн хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 87.8 хувь, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалт 88.4 хувь байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

8225020119

Аймгийн хэмжээнд хэрэгжсэн “Боловсролын чанарыг сайжруулах” хөтөлбөрийн санхүүжилт тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжсан ба зарцуулалт болох 3,473,474.9 мянган төгрөг нь боловсролын салбарын байгууллага, ажилтан албан хаагч, оюутан, сурагчдад шагнал урамшуулал, дэмжлэг, тэтгэмж түүний батламжийн үнэ байна.

Тайлант онд Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын А/80 дугаар тушаалын дагуу математик, англи хэлний цахим сургалтын хөтөлбөр хэрэгжиж ерөнхий гэрээний дагуу патентын эрхийн төлбөрийг нэгжүүдээс төлж шууд зардлаар тайлагнасан байна.

Боловсролын салбарын байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын үнэ тариф нэмэгдсэн нь тайлант онд өр үүсэх шалтгаан болсон байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд Боловсролын газрын төсөв захирагч 16 зорилт 79 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, Боловсролын сайд биелэлтийг 92.91 хувь гэж дүгнэсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Г.ГҮНЖИДМАА

Говь-Алтай аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	/мян.төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2023.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	784,784.7	919,240.4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,344,052.9	5,299,398.6
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>6,128,837.6</b>	<b>6,218,639.0</b>
Нийт өр төлбөрийн дүн	-	13.3
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,128,837.6	6,218,625.8
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>6,128,837.6</b>	<b>6,218,625.8</b>
Үйл ажиллагааны орлогын дүн	2,474,227.1	3,903,369.7
Үйл ажиллагааны зардлын дүн	2,655,498.1	3,812,581.5
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(181,271.0)</b>	<b>90,788.2</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	-	(1,000.0)
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(181,271.0)</b>	<b>89,788.2</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		
Тайлант оны үр дүн		
<b>Эцсийн үлдэгдэл</b>		
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,123,942.7	3,129,777.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,090,921.7	3,106,967.2
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>33,021.0</b>	<b>22,810.6</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(33,021.0)</b>	<b>(22,810.6)</b>
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>2,891,864.1</b>	<b>3,167,168.1</b>
Урсгал зардал	2,891,864.1	3,167,168.1
Хөрөнгийн зардал	-	-
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>2,891,864.1</b>	<b>3,167,168.1</b>
Улсын төсвөөс санхүүжих	2,891,864.1	3,167,168.1
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

ГАА-2024/149/НА-СТА-ТШЗ



## Аудитын илрүүлэлт

Аудитаар 1,371,698.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**
  - Бараа материалд дээд газрын данс тооцоонд бүртгэлтэй 66,044.1 мянган төгрөгийн номыг давхар бүртгэсэн,
  - Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан алан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардлын зүйл ангийг 91,984.7 мянган төгрөгийн зөрүүлэн тайлагнасан
  - Нэмэлт төсвийн гүйцэтгэлд төсвийн хэлбэлзлээс орлогын нэр төрлийг 1,213,670.0 мянган төгрөгийг зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 38,476.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 38,476.9 мянган төгрөгийн 6 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 31,262.5 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7,214.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 2 албан шаардлага хүргүүлж, үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах 1 зөвлөмж өгсөн.

### Төлбөрийн акт

1. Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал нэрээр 2,269.0 мянган төгрөг тушаал шийдвэргүйгээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2.2-т "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид", 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:  
Төсвийн орлого болгох  
төлбөрийн акт тогтоосон

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Албан хаагчдад үндсэн ажлаа гүйцэтгэсний төлөө 8,215.0 мянган төгрөгийн нэмэгдэл, тооцооллын алдаа гаргаж 591.1 мянган төгрөг илүү, 187.4 мянган төгрөг дутуу цалин олгосон нь Боловсролын газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Б/26, 27 дугаар тушаал, 2024 оны 03 дугаар сарын 21 ний өдрийн Б/31, 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн Б/47 дугаар тушаал, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1-т "Гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр тогтоогоогүй бол хөдөлмөрийн нормыг үндэслэлтэй тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөж байгаа цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2-т "Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон

3. Тус байгууллагын нэр бүхий 4 ажилтан нэмэлт санхүүжилтийн данснаас 20,000.0 мянган төгрөгийн дэмжлэг авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй үнэн зөв байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон

### Албан шаардлага

1. Хэвлэл мэдээллийн үйлчилгээний төлбөрт 2,283.9 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэвлэл мэдээллийн үйлчилгээний төлбөрт төсвийг үр ашиггүй зарцуулж буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах арга зүйчийн албан тушаалын тодорхойлолтод заасан "албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргуулах" чиг үүргийг архив бичиг хэргийн ажилтанд хавсруулан нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Боловсролын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/30 дугаар тушаалын 18 дугаар хавсралт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1-т "гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр тогтоогоогүй бол хөдөлмөрийн нормыг үндэслэлтэй тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөж байгаа цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг өөр ажилтанд шилжүүлэн төсвийг үр ашиггүй зарцуулж буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

### **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан төсвийн хөрөнгө бүхэлдээ боловсролын салбарын ажилтан албан хаагч, оюутан, сурагчдад шагнал урамшуулал, дэмжлэг, тэтгэмж түүний батламж нэрээр 3,372,666.4 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэлт төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, хуульд заагаагүй тэтгэмж шагнал урамшуулалд зарцуулахгүй байх, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Боловсролын газар	3	1,371.7			3	1,371.7	3	1,371.7				
Дүн	3	1,371.7			3	1,371.7	3	1,371.7				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		ХХБ-д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Боловсролын газар	4	33.5	3	31.3	1	2.3	-	-	-	-	-	-
Дүн	4	33.5	3	31.3	1	2.3	-	-	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Боловсролын газар	1	4.9	-	-	1	4.9	-	-
Дүн	1	4.9	-	-	1	4.9	-	-
-Нийт дүн	5	38.4	3	31.3	2	7.2	-	-

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзса
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	<b>НИЙТ</b>		<b>1</b>			<b>1</b>			